



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/295


Арвайхээр

Гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд баригдах 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэг маягийн зураг, төсвийн холболтын зургийг 17.500.000 (арван долоон сая таван зуун мянга) төгрөгөөр "Бест онцгой дизайн" ХХК-тай гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд зураг төсвийг хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.
3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100643